



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/84/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Ахлах аудитор:	Цахим хаяг: domogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Э.Эрдэнэсүвд Цахим хаяг: erdenesuvde@audit.gov.mn
---	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.Хараат бус аудиторын дүгнэлт



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2026.02.23 № 1-6/80

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илрүүлсэн залруулагдаагүй 59.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин болох 31.6 сая төгрөгөөс давсан бөгөөд өргөн тархаагүй байгаа нь өөрчлөлттэй дүгнэлт өгөх үндэслэл бүхий байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 40.1 сая төгрөгийн өвс тэжээл худалдан авч, хадлангийн тоног төхөөрөмж түрээсэлсний төлбөрт 82.5 сая төгрөгийн өвс тэжээл үнэ төлбөргүй хүлээн авсан ба 46.1 сая төгрөгийн өвс тэжээлийг хямдралтай үнээр зарж, 160.7 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөцтэй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 7.1 сая төгрөгийн гадаад албан томилолтын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гарган зарцуулсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дугаар заалтыг зөрчиж 13 албан хаагчид 2.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон, 5.1.5 дугаар заалтыг зөрчиж 20.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу 3.6 сая төгрөгийн ажил гүйлгээ гаргасан байна.

442505045

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,200,756,392.31</u></b>	<b><u>1,007,562,417.19</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3,857,667.00	2,007,667.00
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	3,857,667.00	2,007,667.00
3121	<b>Төгрөг</b>	3,857,667.00	2,007,667.00
31211	Төрийн сангийн харилцах	3,857,667.00	2,007,667.00
33	<b>АВЛАГА</b>	487,480,469.10	64,815,199.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,483,940.00	919,000.00
335	<b>Бусад авлага</b>	485,996,529.10	63,896,199.10
3351	Байгууллагаас авах авлага	451,685,631.10	63,354,065.10
3352	Хувь хүмүүсээс авах авлага	34,310,898.00	542,134.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7,220,000.00	6,920,000.00
3471	<b>Урьдчилгаа тооцоо</b>	7,220,000.00	6,920,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,920,000.00	6,920,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	300,000.00	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	702,198,256.21	933,819,551.09
351	<b>Түүхий эд материал</b>	104,776,613.50	318,334,173.50
35110	Тусгай зориулалттай материал	101,848,913.50	315,813,173.50
35130	Эм боох материал	2,927,700.00	2,521,000.00
354	<b>Хангамжийн материал</b>	577,521,642.71	595,585,377.59
35410	Бичиг хэргийн материал	27,788,551.00	8,797,300.00
35420	Аж ахуйн материал	123,087,124.21	79,808,954.01
35430	Сэлбэг хэрэгсэл	31,861,750.00	32,061,750.00
35440	Түлш, шатах тослох материал	8,440,735.50	1,646,280.58
35460	Хүнсний материал	24,068.00	32,179.00
35470	Бусад хангамжийн материал	386,319,414.00	473,238,914.00
35600	Мал амьтад	19,900,000.00	19,900,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>14,455,201,562.90</u></b>	<b><u>8,768,287,951.19</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	14,455,201,562.90	8,768,287,951.19
392	<b>Биет хөрөнгө</b>	13,673,794,470.20	8,484,518,867.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,686,647,891.50	4,016,301,256.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(446,790,884.50)	(584,855,525.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	430,283,950.00	630,095,061.14
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,163,712.18)	(112,677,548.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	379,857,635.00	938,516,404.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,767,994.78)	(193,358,528.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	183,942,785.60	160,547,268.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,114,516.84)	(79,977,661.00)
39209	Зам, гүүрийн байгууламж	10,556,316,102.70	2,003,452,113.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,784,009,078.90)	(499,226,787.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,713,996,061.70	4,431,162,080.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,827,273,969.10)	(2,227,329,465.18)
39217	Ном	1,870,200.00	1,870,200.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	781,407,092.70	283,769,083.46
39301	Програм хангамж	10,086,000.00	10,086,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,210,041.30)	(4,971,916.54)
39303	Бусад биет бус хөрөнгө	774,531,134.00	278,655,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>15,655,957,955.21</u></b>	<b><u>9,775,850,368.38</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,321,854.02</u></b>	<b><u>26,146,827.94</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,321,854.02</b>	<b>26,146,827.94</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,321,854.02</b>	<b>26,146,827.94</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,321,854.02	14,412,829.94
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,257,848.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>-</b>	<b>6,476,150.00</b>

41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,844,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	631,550.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,654,636,101.19</b>	<b>9,749,703,540.44</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	15,654,636,101.19	9,749,703,540.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	593,513,848.97	593,513,848.97
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	14,660,847,980.10	8,755,915,419.35
51210	Өмнөх үеийн үр дүн	14,660,847,980.10	14,660,847,980.10
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,904,932,560.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	400,274,272.12	400,274,272.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>15,655,957,955.21</b>	<b>9,775,850,368.38</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>7,593,281,412.45</b>	<b>6,474,086,604.64</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,246,146,010.13</b>	<b>2,353,057,626.64</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,246,146,010.13	2,353,057,626.64
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,246,146,010.13	1,969,100,866.64
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		383,956,760.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,347,135,402.32</b>	<b>4,121,028,978.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,328,916,080.00	921,093,478.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,242,892,749.00	893,566,758.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,023,331.00	27,526,720.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	3,018,219,322.32	3,199,935,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,018,219,322.32	3,199,935,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,730,418,423.70</b>	<b>5,918,522,420.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,730,418,423.70</b>	<b>5,918,522,420.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,713,508,423.70	5,857,814,200.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,142,874,872.04	2,261,408,465.16
210101	Үндсэн цалин	996,191,315.14	919,543,841.07
210102	Нэмэгдэл	673,646,087.55	662,239,070.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	143,111,000.00	188,282,000.00
210104	Урамшуулал	111,527,000.00	154,902,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	218,399,469.35	336,440,753.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	263,948,169.02	271,004,562.29
210201	Тэтгэврийн даатгал	181,642,935.86	185,504,314.26
210202	Тэтгэмжийн даатгал	21,850,632.49	22,716,684.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,934,288.40	11,643,366.75
210204	Ажилгүйдлийн даатгал	9,904,062.50	10,214,835.03
210205	Эрүүл мэндийн даатгал	39,616,249.77	40,925,361.59
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	148,074,182.43	148,750,544.34
210301	Гэрэл, цахилгаан	11,941,157.43	11,920,633.74
210302	Түлш, халаалт	125,668,615.00	127,854,956.00
210303	Цэвэр, бохир ус	10,464,410.00	8,974,954.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	74,993,920.60	140,952,861.12
210401	Бичиг хэрэг	13,621,500.00	34,248,282.00

210402	Тээвэр, шатахуун	40,265,715.60	32,956,771.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,320,359.00	17,260,167.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,546,346.00	56,487,640.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,473,054.00</b>	<b>89,353,623.00</b>
210604	Урсгал засвар	11,473,054.00	89,353,623.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,452,700.00</b>	<b>2,308,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,452,700.00	2,308,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,885,464,248.00</b>	<b>1,708,179,646.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,871,790,003.00	1,695,486,898.80
210803	Даатгалын үйлчилгээ	1,141,300.00	1,356,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	406,230.00	247,808.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	12,060,715.00	11,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,184,227,277.61</b>	<b>1,235,856,497.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	535,628,592.00	10,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,015,000.00	1,339,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,645,583,685.61	1,224,016,997.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,910,000.00</b>	<b>60,708,220.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,910,000.00</b>	<b>32,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,910,000.00	32,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>28,708,220.33</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	28,708,220.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(137,137,011.25)</b>	<b>555,564,183.82</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,005,116.16</b>	<b>6,460,496,744.57</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	20,005,116.16	6,449,016,244.57
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		11,480,500.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(20,005,116.16)</b>	<b>(6,460,496,744.57)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(157,142,127.41)</b>	<b>(5,904,932,560.75)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл / төгрөгөөр /
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>6,756,086,926.15</b>	<b>4,551,780,691.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,000,000.00</b>	<b>18,050,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,000,000.00</b>	<b>18,050,000.00</b>
120009	Бусад орлого	10,000,000.00	18,050,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,746,086,926.15</b>	<b>4,533,730,691.38</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,554,164,125.10</b>	<b>1,333,795,191.38</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,242,892,749.00	893,566,758.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	311,271,376.10	440,228,433.38
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>3,191,922,801.05</b>	<b>3,199,935,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,191,922,801.05	3,199,935,500.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>6,201,039,395.05</b>	<b>4,550,580,691.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,201,039,395.05</b>	<b>4,550,580,691.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,183,531,395.05</b>	<b>4,463,028,705.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,154,185,204.62</b>	<b>2,276,263,742.52</b>
210101	Үндсэн цалин	940,793,926.93	921,139,864.26
210102	Нэмэгдэл	701,743,952.93	676,205,629.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	142,744,000.00	187,555,201.55
210104	Урамшуулал	121,274,648.07	145,222,293.78
210105	Гэрээт ажлын хөлс	247,628,676.69	346,140,753.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>262,901,200.00</b>	<b>260,243,369.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	176,496,000.00	184,118,834.24
210202	Тэтгэмжийн даатгал	19,083,900.00	36,063,820.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,325,300.00	9,754,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,273,000.00	3,264,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,723,000.00	27,041,714.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>147,832,182.43</b>	<b>148,750,544.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,941,157.43	11,920,633.74
210302	Түлш, халаалт	125,668,615.00	127,854,956.00
210303	Цэвэр, бохир ус	10,222,410.00	8,974,954.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>62,150,216.00</b>	<b>47,610,027.00</b>
210401	Бичиг хэрэг	15,992,140.00	11,503,850.00
210402	Тээвэр, шатахуун	23,552,969.00	14,041,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,344,009.00	16,763,867.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,021,098.00	5,301,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,438,624.00</b>	<b>97,662,935.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,336,764.00	-
210604	Урсгал засвар	18,101,860.00	97,662,935.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,452,700.00</b>	<b>2,308,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,452,700.00	2,308,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,955,217,676.00</b>	<b>1,616,687,388.08</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,941,543,431.00	1,604,530,740.08
210803	Даатгалын үйлчилгээ	1,141,300.00	853,840.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	406,230.00	247,808.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	12,060,715.00	11,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>566,353,592.00</b>	<b>13,502,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	560,628,592.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,725,000.00	8,502,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,508,000.00</b>	<b>87,551,985.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,508,000.00</b>	<b>32,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,508,000.00	32,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>55,551,985.43</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	28,708,220.33
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	-	26,843,765.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>555,047,531.10</b>	<b>1,200,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>151,225,000.00</b>	<b>3,050,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>151,225,000.00</b>	<b>3,050,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>151,225,000.00</b>	<b>3,050,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	102,725,000.00	3,050,000.00
223001	Бусад хөрөнгө	48,500,000.00	-

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (6)=(4)-(5)	<b><u>(151,225,000.00)</u></b>	<b><u>(3,050,000.00)</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (8)=(3)+(6)+(7)	403,822,531.10	<b><u>(1,850,000.00)</u></b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,857,667.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,857,667.00	2,007,667.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	593,513,848.97	400,274,272.12	14,660,847,980.10	15,654,636,101.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>593,513,848.97</b>	<b>400,274,272.12</b>	<b>14,660,847,980.10</b>	<b>15,654,636,101.19</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>593,513,848.97</b>	<b>400,274,272.12</b>	<b>14,660,847,980.10</b>	<b>15,654,636,101.19</b>
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>593,513,848.97</b>	<b>400,274,272.12</b>	<b>14,660,847,980.10</b>	<b>15,654,636,101.19</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>593,513,848.97</b>	<b>400,274,272.12</b>	<b>14,660,847,980.10</b>	<b>15,654,636,101.19</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин	-	-	-	-

	үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,904,932,560.75)	(5,904,932,560.75)
D09	<b>2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл</b>	<b>593,513,848.97</b>	<b>400,274,272.12</b>	<b>8,755,915,419.35</b>	<b>9,749,703,540.44</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Гүйцэтгэл / төгрөгөөр /
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,371,547,300.00	3,171,227,279.67	200,320,020.33	94.06
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,371,547,300.00	3,171,227,279.67	200,320,020.33	94.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,324,447,300.00	3,159,127,279.67	165,320,020.33	95.03
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,293,611,700.00	2,276,263,742.52	17,347,957.48	99.24
210101	Үндсэн цалин	941,223,600.00	921,139,864.26	20,083,735.74	97.87
210102	Нэмэгдэл	688,689,000.00	676,205,629.18	12,483,370.82	98.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,240,000.00	187,555,201.55	(31,315,201.55)	120.04
210104	Урамшуулал	151,491,100.00	145,222,293.78	6,268,806.22	95.86
210105	Гэрээт ажлын хөлс	355,968,000.00	346,140,753.75	9,827,246.25	97.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	310,906,600.00	260,243,369.01	50,663,230.99	83.70
210201	Тэтгэврийн даатгал	207,852,000.00	184,118,834.24	23,733,165.76	88.58
210202	Тэтгэмжийн даатгал	24,792,000.00	36,063,820.17	(11,271,820.17)	145.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,873,300.00	9,754,100.00	10,119,200.00	49.08
210204	Ажилгүйдлийн даатгал	6,873,300.00	3,264,900.00	3,608,400.00	47.50
210205	Эрүүл мэндийн даатгал	51,516,000.00	27,041,714.60	24,474,285.40	52.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	159,433,200.00	148,750,544.34	10,682,655.66	93.30
210301	Гэрэл, цахилгаан	14,200,000.00	11,920,633.74	2,279,366.26	83.95
210302	Түлш, халаалт	134,749,400.00	127,854,956.00	6,894,444.00	94.88
210303	Цэвэр, бохир ус	10,483,800.00	8,974,954.60	1,508,845.40	85.61
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	66305800.00	47610027.00	18,695,773.00	71.80
210401	Бичиг хэрэг	16000000.00	11503850.00	4,496,150.00	71.90
210402	Тээвэр, шатахуун	22612800.00	14041160.00	8,571,640.00	62.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,253,000.00	16,763,867.00	2,489,133.00	87.07
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	-	240,000.00	0.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,200,000.00	5,301,150.00	2,898,850.00	64.65
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	89,000,000.00	97,662,935.00	(8,662,935.00)	109.73
210604	Урсгал засвар	89,000,000.00	97,662,935.00	(8,662,935.00)	109.73
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,750,000.00	2,308,000.00	3,442,000.00	40.14
210702	Дотоод албан томилолт	5,750,000.00	2,308,000.00	3,442,000.00	40.14
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	379,690,000.00	312,785,961.80	66,904,038.20	82.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	364,020,000.00	300,629,313.80	63,390,686.20	82.59
210803	Даатгалын үйлчилгээ	950,000.00	853,840.00	96,160.00	89.88
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	247,808.00	402,192.00	38.12
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	55,000.00	35,000.00	61.11
210807	Газрын төлбөр	13,980,000.00	11,000,000.00	2,980,000.00	78.68
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,750,000.00	13,502,700.00	6,247,300.00	68.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,750,000.00	8,502,700.00	6,247,300.00	57.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	47,100,000.00	12,100,000.00	35,000,000.00	25.69
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	47,100,000.00	12,100,000.00	35,000,000.00	25.69
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,100,000.00	12,100,000.00	35,000,000.00	25.69
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,371,547,300.00	3,199,935,500.00	171,611,800.00	94.91
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,371,547,300.00	3,199,935,500.00	171,611,800.00	94.91
132001	Орон нутгийн төсвөөс	3,371,547,300.00	3,199,935,500.00	171,611,800.00	94.91

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	1,333,795,191.38
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	1,333,795,191.38
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	1,306,951,426.28
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	1,306,951,426.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,306,951,426.28
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>26,843,765.10</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,843,765.10
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	1,333,795,191.38
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	1,333,795,191.38
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	893,566,758.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	440,228,433.38

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>19,900,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,900,000.00</b>
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,900,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,900,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,900,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>18,050,000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18,050,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,050,000.00
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,857,667.00</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,007,667.00</b>

## 5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 86,219.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа.

### Залруулсан алдаа:

- Тээвэр шатахууны зардал 224,800 төгрөгийг үндсэн цалингийн зардалд бичсэн, (Завсрын аудит)
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,283,000 төгрөгийн бичиг хэргийн зардал, 5,257,848 төгрөгийн шатахууны зардал, 949,999.96 төгрөгийн элэгдлийн зардлыг Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд /210801/ бичсэн, Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 27,667,922.3 төгрөгөөр, бараа материалыг 49,816,000 төгрөгөөр алдаатай илэрхийлсэн зэрэг алдаа нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 59,967.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 15,628.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 34,389.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 9,950.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 59,967.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 28,381.1 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Албан томилолтоор ажилласан 5 албан хаагчид хоол, унааны хөнгөлөлт 220,000 (хоёр зуун хорин мянган) төгрөгийг давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.3-д “*хоолны зардал*” гэж заасантай нийцэхгүй байна.

5.1.2. Тус байгууллага нь 2024.07.18-ны өдрийн 01 дугаартай эд хөрөнгө ашиглах гэрээг 4 жилийн хугацаатай Тахилт агро ХХК-тай байгуулан түрээсийн төлбөрт нийт 15,000 боодол өвс тэжээлийг хуваарийн дагуу авахаар халилцан тохиролцсон боловч 2025 оны тайлант хугацаанд 3500 боодол өвс, тэжээл хүлээн авахаас 1229 боодлыг хүлээн авч, 2,271 боодол өвс тэжээл дутуу авч гэрээний үүргийн биелэлтийг хангуулан ажиллаагүйд 11,082.5 мянган төгрөгийн алдангийг тооцоогүй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 “*Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ*”, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газартай байгуулсан 2024.07.18-ны өдрийн 01 дугаартай эд хөрөнгө ашиглах гэрээний 4.4 “*ашиглаж байгаа эд хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хийгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданга ногдуулна*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.1.3. Хэнтий аймгийн Биндэр сум руу туршлага судлахаар явах үеийн замын хүнсэнд гэж 330,564 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас, шатахууны зардалд 2,796,360 төгрөгийг, сургалтын хэрэглэгдэхүүн 500,000 төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас тус тус гарган зарцуулсан боловч сургалт зохион байгуулж, туршлага солилцсон ажлын тайлан мэдээ, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*үр ашигтай байх*”, 4.1.6 “*сахилга баттай байх*”, 4.1.7 “*бодитой байх*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.1.4. Сумын Засаг даргын 2025.01.29-ний өдрийн А/15 дугаар захирамжаар Тайвань улсын Тайпай хотод зохион байгуулагдах “Ухаалаг хотуудын дээд хэмжээний уулзалт-Экспо 2025” арга хэмжээнд оролцох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн онгоцны тийзийн зардал болох 8.9 сая төгрөгийг “Эрүүл хот хөтөлбөрийг хэрэгжүүлэх” ТББ- руу шилжүүлсэн. Гэвч тухайн арга хэмжээнд оролцох боломжгүйн улмаас тийзийн 8.2 сая төгрөгийг буцааж, 0.7 сая төгрөгийг шимтгэлд суутгаж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*үр ашигтай байх*”, 4.1.6 “*сахилга баттай байх*”, 4.1.7 “*бодитой байх*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1. Тус байгууллага нь завсрын аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлаас шуудан холбооны зардалд 517,000 төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 4,632,700 төгрөг, нийт 5,150,000 төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна. (Завсрын аудитаар)

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

5.2.2. Тус байгууллага нь 2024.07.18-ны өдрийн 01 дугаартай эд хөрөнгө ашиглах гэрээг 4 жилийн хугацаатай Тахилт агро ХХК-тай байгуулан түрээсийн төлбөрт нийт 15,000 боодол өвс тэжээлийг хуваарийн дагуу авахаар халилцан тохиролцсон боловч 2024 оны гэрээний төлбөрийг 2025 онд барагдуулсан, 2025 оны гэрээний төлбөрийг дутуу /2,271 боодол өвс, тэжээл/ төлсөн байхад гэрээнд заагдсан чиг үүргийг хангуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 “Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ”, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газартай байгуулсан 2024.07.18-ны өдрийн 01 дугаартай эд хөрөнгө ашиглах гэрээний 9 “Гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл”, 9.1 “Ашиглагч нь ашиглаж байгаа эд хөрөнгийн төлбөрөө 2 сар хүртэл хугацаагаар хожимдуулан төлөх, гэрээ болон хуульд заасан нөхцөл бүрдэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2.3. Тайлант хугацаанд 4 албан хаагчыг БНСУ- руу албан томилолтоор ажиллуулж, ирж буцах онгоцны билетийн зардалд 7,163,200 төгрөгийг зарцуулахдаа 4,963,200 төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2,200,000 төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гарган эдийн засгийн ангилал зөрчиж ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2.4. Байгууллагын даргын 2025.12.08 өдрийн А/90 дүгээр тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгө, материалын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг томилсон боловч хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу зохион байгуулаагүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2.5. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 18,177 м2 хэмжээ бүхий 17 нэгж талбар бүртгэлтэй байхад тайлант хугацаанд 39 нэгж талбарт ногдуулсан 11.0 сая төгрөгийн газрын төлбөрийг батлагдсан төсвөөс шилжүүлэн зарцуулсан ба 22 нэгж талбарыг байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгахгүйгээр газрын төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2.6. Тайлант хугацаанд байгууллагын батлагдсан төсвөөс 20.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, сумын Засаг даргын 2025.01.30-ны өдрийн А/06 дугаар захирамжаар 13 албан хаагчид 2.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 5.3 Зөвлөмж

#### 1. Бараа материалын данстай холбоотой

1.1. Илрүүлэлт: Тус байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 10 толгой бухан бярууг 2023 онд худалдан авч Сайншанд сумын малчин өрхүүдэд гэрээгээр 2 жилийн хугацаатай ашиглуулж байсан ба 5 малчны хариуцсан 5 толгой бух хорогдсон тухай Сайншанд сумын ХАА мэргэжилтний тайлбар ирүүлсэн байна. Гэвч хорогдсон бухыг данс бүртгэлд үлдэгдлээр тайлагнаж, буруутай этгээдээс авах авлагыг тусгаагүй, төлбөрийг гэрээнд заасны дагуу малчнаас гаргуулах ажлыг зохион байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө, эд хөрөнгө дутагдсан үед заавал хийнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Малчин хөлсөөр ажиллуулах гэрээний 3.6-д “Хээлтүүлэг алдсан, үхэж үрэгдүүлсэн тохиолдолд малчин хариуцлагыг бүрэн хүлээж тухайн үеийн зах зээлийн ханшаар бүрэн барагдуулна” гэж заасантай нийцээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Мал амьтны дансанд бүртгэлтэй 9950.0 мянган төгрөгийн 5 толгой бухыг бараа материалын данснаас хасаж, буруутай этгээдээс авах авлага үүсгэж, төлбөрийг гэрээнд заасны дагуу барагдуулах ажлыг зохион байгуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	
НББ-ын данс хөтлөлтийн алдаа	1	224.8	-	-	1	224.8	1	224.8	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн алдаа	1	85,974.8	-	-	1	85,974.8	1	85,974.8	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>86,199.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>86,199.6</b>	<b>2</b>	<b>86,199.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/							
			Үүнээс				Хариуцлага тооцуулах			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн	1	5,150.0	-	-	1	5,150.0	-	-	-	-
Хоол, унааны мөнгийг албан томилолттой давхардуулан олгосон	1	220.0	1	220.0		-	-	-	-	-
Мал, амьтны бүртгэлийг алдаатай бүртгэсэн	1	9,950.0	-	-	-	-	1	9,950.0	-	-
Түрээсийн төлбөрийн төлөгдөөгүй дүнд алданги тооцоогүй	1	11,082.5	1	11,082.5	-	-	-	-	-	-
Гэрээний үүргийн биелэлтийг хангуулан ажиллаагүй	1	-	-	-	1	-	-	-	-	-
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ гаргасан	1	3,626.9	1	3,626.9	-	-	-	-	-	-
Гадаад албан томилолтын зардлын төсөвгүй байхад гадаад албан томилолтын зардал гаргасан	1	7,163.2	-	-	1	7,163.2	-	-	-	-
Билет буцаалтын шимтгэлд төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	698.6	1	698.6	-	-	-	-	-	-
Байгууллагын эзэмшлийн газрыг балансад бүртгээгүй	1	-	-	-	1	-	-	-	-	-
Хөрөнгийн тооллого чанаргүй зохион байгуулсан	1	-	-	-	1	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3, 15.1.5 дугаар заалтуудыг зөрчиж бэлэг дурсгал, мөнгөн шагнал олгосон	1	22,076.5	-	-	1	22,076.5	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>59,967.7</b>	<b>4</b>	<b>15,628.0</b>	<b>6</b>	<b>34,389.7</b>	<b>1</b>	<b>9,950.0</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн хэрэгжилт	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>